

“ЭРДЭНЭС ХҮНС” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2024 оны 04 сарын 30 өдөр

Улаанбаатар хот

“Эрдэнэс Хүнс” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2024 оны 04 сарын 30-ны өдрийн 16:00 цагт Орхон аймгийн Баян-Өндөр сумын Баянцагаан баг “Эрдэнэт хүнс” хувьцаат компанийн байранд эхлэв.

Хурлын ирц:

Хурлын дэгийн дагуу 16:10 хүртэл ирц бүртгэсэн.

Тооллогын комиссын дарга Ч.Амаржаргал-ын танилцуулснаар:

Компанийн 254,620 ширхэг хувьцааг эзэмшиж буй 2 хувьцаа эзэмшигч хуралд оролцож байгаа нь нийт саналын эрхтэй 394,298 ширхэг энгийн хувьцааны 64.58% болж байна. Иймд “Компанийн тухай” хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1, 69.2 дах заалтыг үндэслэн хурлын ирцийг хүчин төгөлдөрт тооцов.

Хурлын дарга Д.Сүхбат хурлын хэлэлцэх асуудлуудыг танилцуулав. Үүнд:

1. Компанийн 2023 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаархи Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах
2. Компанийн 2024 оны бизнес төлөвлөгөөний үндсэн чиглэлийг хэлэлцэн батлах
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох
4. Бусад

Хэлэлцсэн нь:

1. Компанийн 2023 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаархи Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэв.

“Эрдэнэс Хүнс” ХК-ийн Гүйцэтгэх захирал Д.Баасандорж Компанийн 2023 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаархи Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг танилцуулав.

Хувьцаа эзэмшигчдийн зүгээс компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар тодруулга, нэмэлт асуулт байхгүй.

2. Компанийн 2024 оны бизнес төлөвлөгөөний үндсэн чиглэлийг хэлэлцэв.

“Эрдэнэс Хүнс” ХК-ийн Гүйцэтгэх захирал Д.Баасандорж Компанийн 2024 оны бизнес төлөвлөгөөний үндсэн чиглэлийг танилцуулав.

Хувьцаа эзэмшигчдийн зүгээс Компанийн 2024 оны бизнес төлөвлөгөөний үндсэн чиглэлийг талаар тодруулга, нэмэлт асуулт байхгүй.

3. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг сонгов.

Хурлын дарга Д.Сүхбат компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар Төлөөлөн Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг дахин сонгохтой холбоотойгоор ТУЗ-ийн нэр дэвшигчдийг танилцуулж, мэдээлэл хүргэв. Нэр дэвшигчдийн мэдээлэл:

Ердийн гишүүнд нэр дэвшигч:

- Даваацэрэн-н Сүхбат
- Рэнчээ-н Мөнгөншагай
- Рэнчээ-н Дарьчулуун
- Янжив-н Алтанцэцэг
- Чулуунбаатар-н Амаржаргал
- Мөөсөө-н Энхмаа

Хараат бус гишүүнд нэр дэвшигч

- Дэржээ-н Цэвээнжав
- Түдэв-н Амарсанаа
- Ариуна-н Идэрбат

Мөн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас тус асуудалтай холбоотой гарах тогтоолын төслийг хувьцаа эзэмшигчдэд уншиж танилцуулав.

4. Бусад асуудал

“Эрдэнэс Хүнс” ХК-ийн 2024 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай шийдвэр, хурлын танилцуулах материал, саналын хуудсанд тус асуудлыг хэлэлцүүлэхээр тусгасан байсан боловч хувьцаа эзэмшигчдийн хурлын үеэр дээрхтэй холбоотой ямарваа нэгэн асуудал хэлэлцээгүй.

Санал хураалт:

Хурлаар хэлэлцэх асуудлуудыг хэлэлцүүлсний дараа тооллогын комиссын дарга Ч.Амаржаргал санал хураалт эхэлж буйг мэдэгдэж, хэлэлцэж байгаа нийт 3 асуудлын 2-д нь ердийн аргаар, 1 асуудал буюу ТУЗ-ийн гишүүдийг сонгох асуудалд кумулятив аргаар санал хураахыг дурдав.

Санал хураалт явагдаж дуусав.

Тооллогын комиссын дарга Ч.Амаржаргал санал хураалтын дүнг танилцуулав.

Хурлаар дараах асуудлуудыг ердийн аргаар санал хураан шийдвэрлэв.

1. Компанийн 2023 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаархи Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах;

Зөвшөөрсөн – 254,620 ширхэг хувьцаа буюу 100%

Татгалзсан - 0 ширхэг хувьцаа буюу 0%

Түдгэлзсэн - 0 ширхэг хувьцаа буюу 0%

2. Компанийн 2024 оны бизнес төлөвлөгөөний үндсэн чиглэлийг хэлэлцэн батлах;

Зөвшөөрсөн – 254,620 ширхэг хувьцаа буюу 100%

Татгалзсан - 0 ширхэг хувьцаа буюу 0%

Түдгэлзсэн - 0 ширхэг хувьцаа буюу 0%

Хурлаар дараах асуудлыг кумулятив аргаар санал хураан шийдвэрлэв.

3. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг сонгох

Саналын хуудсаар “Эрдэнэт Хүнс” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох тухай асуудлаар хуралд оролцсон саналын эрхтэй нийт хувьцаа эзэмшигчдийн өгсөн саналын дүн:

Ердийн гишүүдэд өгсөн санал:

№	ТУЗ-ийн ердийн гишүүнд нэр дэвшигчдийн нэрс	Саналын хувь	Кумулятив аргаар өгсөн саналын тоо
1	Даваацэрэн-н Сүхбат	11.11%	254,620
2	Рэнчээ-н Мөнгөншагай	11.11%	254,620
3	Рэнчээ-н Дарьчулуун	11.11%	254,620
4	Янжив-н Алтанцэцэг	11.11%	254,620
5	Чулуунбаатар-н Амаржаргал	11.11%	254,620
6	Мөөсөө-н Энхмаа	11.11%	254,620

Хараат бус гишүүдэд өгсөн санал:

№	ТУЗ-ийн ердийн гишүүнд нэр дэвшигчдийн нэрс	Саналын хувь	Кумулятив аргаар өгсөн саналын тоо
1	Дэржээ-н Цэвээнжав	11.11%	254,620
2	Түдэв-н Амарсанаа	11.11%	254,620
3	Ариуна-н Идэрбат	11.11%	254,620

тус тус санал авч эдгээр гишүүд ТУЗ-ийн гишүүдэд сонгогдов.

Хурлын шийдвэр:

1. Компанийн 2023 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаархи Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах тухай:
 - 1.1 “Эрдэнэт Хүнс” ХК-ийн 2023 оны үйл ажиллагааны тайлан, санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг баталсугай
2. Компанийн 2024 оны бизнес төлөвлөгөөний үндсэн чиглэлийг хэлэлцэн батлах тухай:
 - 2.1. “Эрдэнэт Хүнс” ХК-ийн Компанийн 2024 оны бизнес төлөвлөгөөний үндсэн чиглэлийг энэхүү тогтоолын хавсралтаар баталсугай.
 - 2.2. Компанийн 2024 оны Компанийн 2024 оны бизнес төлөвлөгөөнд хяналт тавьж ажиллахыг Гүйцэтгэх удирдлагад үүрэг болгосугай.

3. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг сонгох тухай:

3.1 “Эрдэнэс Хүнс” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн гишүүдээр:

1. Даваацэрэн-н Сүхбат
2. Рэнчээ-н Мөнгөншагай
3. Рэнчээ-н Дарьчулуун
4. Янжив-н Алтанцэцэг
5. Чулуунбаатар-н Амаржаргал
6. Мөөсөө-н Энхмаа

3.2 “Эрдэнэс Хүнс” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүдээр:

1. Дэржээ-н Цэвээнжав
2. Түдэв-н Амарсанаа
3. Ариуна-н Идэрбат нарыг тус тус Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдээр сонгогдсоныг баталсугай

Хурлын дарга хурлын хааж үг хэлснээр хурал 18:10 минутад дуусав.

Тэмдэглэл хөтөлсөн:



/Р.Мөнгөншагай/

Хурал зохион байгуулах комиссын дарга

Тэмдэглэл хянасан:

/Д.Сүхбат/

Хурал даргалагч